



ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2017 оны 08 сарын 03 өдөр

Дугаар А/58

Улаанбаатар хот

Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний  
журам, төлбөрийн хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэг, Эрүүл мэнд, спортын сайдын “Жагсаалт, журам батлах тухай” 2016 оны А/228 дугаар тушаалын баталсан журмын 1.3, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 264/А/293 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 21.2-21.110, журмын 1.2-т тус тус заасныг удирдлага болгон ТУШААХ нь:

1.Эмгэг судлалын үндэсний төвөөс үзүүлэх “Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ”-г нэгдүгээр, “Төлбөрт тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэн, эрүүл мэндийн байгууллагуудаас хураах, төвлөрүүлэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эд, эсийн шинжилгээ болон нэмэлт төлбөртэй үйлчилгээний төлбөрийн хураамжинд хяналт тавьж, цахим бүртгэл, санхүүгийн програмд оруулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Санхүү, эдийн засгийн албаны дарга, ахлах нягтлан бодогч М.Саранцэцэг, Лабораторийн эрхлэгч Г.Саруул нарт үүрэг болгосугай.

3.Журам батлагдсантай холбогдуулан төлбөрийн хэмжээ, журмыг байгууллагын вэб сайт, мэдээллийн самбар болон иргэдэд харагдахуйц, ил тод, нээлттэй байдлаар байршуулах, гэрээгээр төлбөрт тусламж, үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хуулийн зөвлөх, дотоод хяналтын ажилтан С.Батбаатарт даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эмгэг судлалын төвийн даргын 2007 оны 27 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ



Г.УЯНГА

УХА0390 912320 E:\2017 он ажил\Zahiraliin A B tushaal\A тушаал.doc

00000125

Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын 2017 оны 48 дугаар сарын 28 ны өдрийн 1/58 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эмгэг судлалын нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ

№	Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний жагсаалт	Төлбөрийн хэмжээ/төгрөгөөр
<b>Нэг.Эд, эсийн шинжилгээ</b>		
1.1	Эд, эсийн шинжилгээ авах(задлах эсийн наац/зүүгээр, түрхэцийн/ биопси/эд/ авах нээлттэй, зүүгээр)	11.500
1.2	Эсийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх	20.000
1.3	Нарийн зүүний хатгалтын шинжилгээ хийх (FNA)	40.000
1.4	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх(зөөлөн эд, бүх төрлийн дурангаар авсан эд)	23.000
1.5	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх(ясны эд)	30.000
1.6	Эдийн шинжилгээ бэлтгэж, онош дүгнэлт өгөх(мэс ажилбараар авсан эд)	33.000
1.7	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторит шинжлэх(эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй)	50.000
1.8	Ясны хэмийн эсийн шинжилгээ авах, лабораторит шинжлэх(эм, эмнэлгийн хэрэгслийн үнэ ороогүй)	80.000
1.9	Хувийн эрүүл мэндийн байгууллагын хүсэлтээр хийх эмгэг судлалын задлан шинжилгээ хийх	53.000
1.10	Иммуногистохимийн шинжилгээ хийх(маркерийн тооноос шалтгаална)	150.000
<b>Хоёр.Нэмэлт тусламж, үйлчилгээний төлбөр</b>		
2.1	Үйлчлүүлэгчийн хүсэлтээр үзүүлэх бусад эмгэг судлалын тусламж, үйлчилгээ болон /экспресс шинжилгээ, молекул генетик гэсэн шинжилгээг хийх/	Тухайн үеийн бодит зардлаар тогтоох

Жич: Иргэн, эрүүл мэндийн байгууллага нь нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг бэлэн бус хэлбэрээр төрийн сан дахь төсвийн харилцах данс болох байгууллагын "Төрийн сан"-ийн 100900020036 тоот дансанд аль ч банкаар дамжуулан төлж болно.

---oOo---

Эмгэг судлалын үндэсний төвийн  
захирлын 2017 оны 18 дугаар сарын 23  
ны өдрийн 158 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



Төлбөрт тусламж, үйлчилгээний төлбөрийг иргэн,  
эрүүл мэндийн байгууллагуудаас хураах, төвлөрүүлэх журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Эрүүл мэндийн тухай хууль болон Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан журмыг үндэслэн Эмгэг судлалын үндэсний төвөөс иргэн, эрүүл мэндийн байгууллагаас үйлчлүүлэгчдэд үзүүлж буй нэмэлт болон төлбөрт үйлчилгээний төлбөрийг иргэн, эрүүл мэндийн байгууллагуудаас хураах, төвлөрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Эмгэг судлалын үндэсний төвөөс нэмэлт болон төлбөртэй үзүүлэх эмгэг судлалын тусламж, үйлчилгээг энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар тогтоосон төлбөрийн хэмжээгээр төлбөртэй үзүүлнэ.

1.3. Төвийн Санхүү, эдийн засгийн алба, Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний алба төлбөртэй тусламж, үйлчилгээтэй холбоотой төлбөрийн хэмжээ, журмыг байгууллагын вэб сайт, мэдээллийн самбар, үйлчлүүлэгчийн хүлээлгийн хэсэгт болон нэг цэгийн дэргэд иргэн, эрүүл мэндийн байгууллагуудад харагдахуйц ил тод, нээлттэй байдлаар байршуулна.

### Хоёр. Төлбөрт тусламж, үйлчилгээний төлбөрийг хураах, төвлөрүүлэх үйл ажиллагаа

2.1. Иргэн, эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх эмгэг судлалын нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг хураах үйл ажиллагааг нэг цэгт төвлөрүүлэн, төвийн захирлаас томилогдсон эмнэлгийн ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

2.2. Нэг цэгт ажиллаж буй эмнэлгийн ажилтан нь энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсаны дагуу иргэн, эрүүл мэндийн байгууллагад үзүүлэх эмгэг судлалтай холбоотой нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ, шинжилгээний төрөл, төлбөрийг төвийн лавлагаа, лабораторийн эрхлэгчийн зөвшөөрлийг үндэслэн төлүүлнэ.

2.3. Иргэн, эрүүл мэндийн байгууллага нь нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг бэлэн бус хэлбэрээр төрийн сан дахь төсвийн харилцах данс болох байгууллагын "Төрийн сан"-ийн 100900020036 тоот дансанд аль ч банкаар дамжуулан төлнө.

2.4.Нэг цэгт ажиллаж буй эмнэлгийн ажилтан нь иргэн, эрүүл мэндийн байгууллагын нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийг төлснийг нотлох баримтыг төвийн лавлагаа, лабораторийн эрхлэгч эсхүл ахлах техникч/лаборант/-д хүлээлгэн өгнө.

2.5.Нэмэлт болон төлбөртэй тусламж, үйлчилгээ авч буй эрүүл мэндийн байгууллага нь гэрээнд заасны дагуу төлбөрийг шинжилгээний төрөл, тоогоор тухайн сарын 30-ны өдрөөр тасалбар болгож нийт дүнгээр бэлэн бус хэлбэрээр энэхүү журмын 2.2-т заасан байгууллагын **100900020036** тоот дансанд нэхэмжлэхийг үндэслэн шууд шилжүүлж болно.

### Гурав.Бусад

3.1.Үйлчлүүлэгчийн хүсэлтээр үзүүлэх бусад эмгэг судлалын тусламж, үйлчилгээ болон экспресс шинжилгээ, молекул генетик гэх мэт шинжилгээтэй холбоотой нэмэлт төлбөрт тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээг тухайн үеийн лабораторийн бодит зардлаар Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын тушаалаар тогтооно.

### Дөрөв.Хориглох зүйл, хариуцлага

4.1.Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтад заасан төлбөрийн хэмжээнээс илүү төлбөр нэхэмжлэх, үйлчлүүлэгчээс албан бус төлбөр авахыг хориглоно.

4.2.Үйлчлүүлэгч төлбөрт тусламж, үйлчилгээтэй холбоотой асуудлаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох хууль хяналтын байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.3.Төвийн эмч, эмнэлгийн ажилтан, лабораторийн техникч нар Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан журам, жишиг хэмжээнээс хэтрүүлэн төлбөр авсан буюу энэхүү журмыг зөрчсөн бол иргэн, эрүүл мэндийн байгууллагад төлбөрийг буцаан олгож, хохирлыг барагдуулах, хөдөлмөрийн тухай хууль, дотоод журам, гэрээнд заасны дагуу хариуцлага ногдуулна.

---oOo---